



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/357

Есөнбулаг сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал, Онцгой комиссын 2026 оны 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Шарга сумын Баянгол багийн урд голын ус хуримтлуулдаг даланг сэргээн засварлахад шаардагдах шатахууны зардал, Цээл сумын Цагаан гол, Цогт сумын Дөтийн давааг нээхэд шаардагдах шатахуун зардал, Тонхил сумын Бүс-Уул багийн нутаг дэвсгэрт эрэн хайх, аврах ажиллагааны дуудлагаар ажилласан шатахууны зардал, Жаргалан сумд гарсан малын гоц халдварт "Боом" өвчний голомтод ажилласан зардал 11425750 болох нийт 16828250 (арван зургаан сая найман зуун хорин найман мянга хоёр зуун тавь) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (М.Насанбат)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч(М.Алтангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 23-ны өдрийн 1/2 дүгээр
захирамжийн ... дугаар хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Зардлын хэмжээ (төгрөг)
1	Шарга сумын Баянгол багийн урд голын ус хуримтлуулдаг даланг сэргээн засварлахад шаардагдах шатахууны зардал	2,150,000
2	Цээл сумын цагаан гол, Цогт сумын дөтийн давааг нээхэд шаардагдах шатахуун зардал	1,520,000
3	Тонхил сумын Бүс-Уул багийн нутаг дэвсгэрт эрэн хайх, аврах ажиллагааны дуудлагаар ажилласан шатахууны зардал	1,735,500
4	Жаргалан сумд гарсан малын гоц халдварт "Боом" өвчний голомтод ажилласан зардал	11,425,750
	НИЙТ	16,828,250

_ оОо _

